



**ДУНГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 1/29

Хажуу шинэ ус

1

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6, Сумын Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Мал аж ахуйн салбарт үр бүтээлтэй ажиллаж байгаа малчин Д.Мөнхжаргал, Л.Баатар, Э.Алтаншагай, Ө.Сүхчулуун, А.Энхсайхан, Б.Баттулга, Д.Төмөрхуяг, П.Доодулам, С.Цэнд-Аюуш, У.Дашдорж нарыг Сумын аварга малчнаар, А.Шинэбаяр, Г.Алтанчимэг, Д.Баяржаргал нарыг Сумын аварга саальчнаар тодруулсугай.

2. Улсын аварга малчин А.Мөнхбат, Аймгийн хошой аварга малчин Б.Оюунбаатар, Алтан төлийн эзэн Х.Мөнх-Очир, Б.Батмөнх, Аймгийн аварга малчин Г.Цогтбаатар, Ж.Мөнх-Оргил, Ш.Баасанхүү, Г.Цогтбаатар, Аймгийн аварга саальчин Б.Өлзийжаргал, Аймгийн аварга тэмээчин Д.Түвшинбаяр, Аймгийн алдарт уяач Н.Мөнхбүрэн нарт хүндэтгэл үзүүлсүгэй.

3. XVII жарны “Элдэв эрдэнэт” хэмээх хөхөгчин модон могой жилийн билгийн тооллын хаврын тэргүүн сарын сар шинийн сумын золголтын арга хэмжээг зохион байгуулж иргэдийг өргөн хамруулж хүндэтгэлтэй хийхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д даалгасугай.

4. Дээрх арга хэмжээний зардалд 8,646,000.00 (Найман сая зургаан зуун дөчин зургаан мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох), Нягтлан бодогч (У.Сүнжидмаа) нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ДОРЖСҮМБЭР

482501020

